



АРИГ БАНК

## АРИГ БАНКНЫ

## ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНИЙ ТАЙЛАН

## П.МӨНХ-ЭРДЭНЭ

## 2024 ОНЫ 03 ДУГААР УЛИРАЛ

2024 оны 10 дугаар  
сарын 15-ны өдөр

Улаанбаатар  
хот

МЭДЭГДЭЛ

Ариг банкны Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”)-ийн Хараат бус гишүүн Пүрэвийн Мөнх-Эрдэнэ миний бие Компанийн тухай хууль (“КтХ”), Банкны тухай хууль (“БтХ”), Монголбанкны холбогдох журмууд болох “Банкны зохицой засаглалын зарчмын хэрэгжилтийн хяналт шалгалтын журам” (“Засаглалын хяналт шалгалтын журам”), “Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн Хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам” (“Хараат бус гишүүний журам”), Ариг банкны Дүрэм болон бусад холбогдох засаглалын бодлого, зарчмын дагуу энэхүү Хараат бус гишүүний тайлан (“Тайлан”)-г бэлтгэсэн болно.

ОРОЛЦОО

Миний бие П.Мөнх-Эрдэнэ нь “Ариг банк” ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл /ТУЗ/-ийн хараат бус гишүүн, ТУЗ-ийн дарга, ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хороо, Засаглал, нэр дэвшүүлэх хорооны гишүүнээр өнгөрсөн хугацаанд ажиллаа.

Тайлант хугацаанд ТУЗ-ийн ээлжит, ээлжит бус хуралд оролцож холбогдох хурлыг удирдаж, тогтоолын төсөл, шийдвэр, дүгнэлт, асуудалд саналаа өгч ажилласан. Хүснэгтээр харуулбал:

*Хуралд оролцсон байдлаар №1:*

№	Хувьцаа эзэмшигчдийн хурал	ТУЗ-ийн хурал	Цалин урамшууллын хорооны хурал	Засаглал нэр дэвшүүлэх хорооны хурал	Нийт оролцсон хурал
1.	-	4	1	-	5

Нийт оролцсон 5 удаагийн хурлаар 16 тогтоол шийдвэр, санал, дүгнэлт гаргасан.

*Хурал хуралдсан огноогоор №2:*

№	Хувьцаа эзэмшигчдийн хурал	ТУЗ-ийн хурал	Цалин урамшууллын хорооны хурал	Засаглал нэр дэвшүүлэх хорооны хурал
1.	-	2024-07-03 2024-07-18 2024-09-10 2024-09-26	2024-07-03	-

*Хараат бус гишүүнээр хуралд заавал санал өгсөн байдлаар №3:*

№	Сонирхлын зөрчилтэй асуудал	Их хэмжээний хэлцэл хийх асуудал
1.	4	-



АРИГ БАНК

Тайлант хугацаанд сонирхлын зөрчилтэй 4 хэлцэлд оролцож дүрмийн дагуу 100% санал нэгдсэн байр суурь, санал зөвлөмжөө өгч, шийдвэр гаргалтад оролцсон бөгөөд дараах асуудлуудыг хэлэлцэн. Үүнд:

ТУЗ-ийн дарга, гишүүний хувьд:

- Хүний нөөцийн бодлого, Эрсдэлийн удирдлагын бодлогыг шинэчлэн батлав.
- Мэдээллийн аюулгүй байдлын болон МУТС бодлого, хөтөлбөрийг шинээр батлав.
- “Ариг банк” ХХК-ийн Хууль, тусгай активын хэлтсийн үйл ажиллагааны 2024 оны 02 дугаар улирлын үйл ажиллагаа, банканд авч хэрэгжүүлж буй арга хэмжээний тайлантай танилцав.
- Банкны 2024 оны 02 улирлын “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны хэрэгжилтийн тайлан”-тай танилцав.
- Банкны 2024 оны 02 дугаар улирлын үйл ажиллагааны болон санхүүгийн гүйцэтгэлийн тайлантай танилцаж ТУЗ-р хэлэлцэв.
- Дотоод аудитын газрын дотоод аудиторыг шинээр томилов.
- Брокерын арилжааны данс нээх эрхийг гүйцэтгэх захиралд олгов.
- “Банкны стратеги төлөвлөгөө 2025-2027 он”-г ТУЗ-р батгуулав.

ТУЗ-ийн хараат бус гишүүний хувьд:

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалтын дагуу сонирхлын зөрчил үүсэж болзошгүй 4 удаагийн хэлцэлд саналаа өгсөн. Санал өгөөгүй хэлцэл байхгүй. Үүнд:

- Гүйцэтгэх захирал болон ТУЗ-ийн гишүүн нь Хөдөлмерийн баатар, Гавьяат эдийн засагч зэрэг төрийн дээд одон медалиар шагнагдсантай холбогдуулан хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу мөнгөн шагнал олгох эсэх асуудлыг журмын дагуу шийдвэрлэв.
- Дотоод аудитын газрын захирлын цалингийн зээлийн хүсэлт, зээл олгохыг дэмжсэн Зээлийн хорооны шийдвэрийг ТУЗ-д танилцуулан, ямарваа нэг давуу байдал олгоогүй, хүү шимтгэлийн ерөнхий нөхцөлийн дагуу байх тул дэмжиж шийдвэрлэв.
- Тендерийн сонгон шалгаруулалтаар шалгарсан “Номин Электроникс” ХХК-с “Dell Power Vault ME5024 Storage Array” загварын Storage серверийг худалдан авах хэлцэл хийж гэрээ байгуулах, гэрэнд “Ариг банк” ХХК-ийг төлөөлөн гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захиралд олгов.

Дээрх хэлцлүүд бүгд харьцуулсан судалгаатай ба ямарваа нэг давуу эрх олгоогүй, сонирхлын зөрчилгүй гишүүд 100%-ийн саналтайгаар тухай бүр дэмжиж шийдвэрлэсэн.

ТУЗ-ийн дэргэдэх Цалин, урамшууллын хорооны хараат бус гишүүний хувьд:

- Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13, 76.1.18 дахь заалтууд, Банкны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.7 дахь заалт, “Ариг банк” ХХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.3 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Цалин, урамшууллын хорооны санал, 2021 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн №494 тоот тушаалт “Ариг банкны шагналын журам”-ын 3.1 дэх заалтыг тус тус үндэслэн Цалин урамшууллын хорооны 2024 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн хурлаар дүгнэлт гаргаж ТУЗ-р хэлэлцүүлэн батгуулав.

ТУЗ-н хараат бус гишүүний хувьд дараах зарчим, зорилтуудад Банк анхаарлаа хандуулж байгааг онцлон хэлмээр байна.

- ТУЗ-н үйл ажиллагаа нь бодлого боловсруулагчаас гаргасан хууль тогтоомжийн дагуу явагддаг.


- Монголбанкнаас ирүүлсэн мэдэгдлийн дагуу шаардлагатай арга хэмжээг цаг тухайд нь хэрэгжүүлж эргэн тайлагнадаг,
- ТҮЗ-с засаж залруулах боломжтой асуудлууд байгаа тохиолдолд бид ТҮЗ-н түвшинд хэлэлцүүлгийг эхлүүлж, үйл ажиллагааг хэрхэн сайжруулах талаар удирдамж өгч, эргэн тайлагнах хугацааг өгдөг. Удирдлагын баг эдгээр хүсэлтийг дагаж мөрдөж, шаардлагатай арга хэмжээг цаг тухайд нь авдаг.
- Тайлангийн хугацаанд Банкны хараат бус гишүүний хувьд банканд сөргөөр нөлөөлөхүйц буруу зүйл илрүүлээгүй тул ямар нэгэн тодорхой асуудлаар ээлжит бус хурал зарлах шаардлага гаргаагүй.
- ТҮЗ нь гаргасан шийдвэр, үндэслэлийн талаар ил тод байж, цаг тухайд нь мэдээлдэг.
- ТҮЗ-ийн хуралдаан дээр хараат бус гишүүний хувьд бусад гишүүдтэй зарчмын зөрүүтэй байр суурь илэрхийлэгдээгүй бөгөөд хэрэв надад асуулт байгаа эсвэл нэмэлт тодруулга авах шаардлагатай бол ТҮЗ болон Удирдлагын багаас зохих мэдээллийг авдаг.
- Мөн эдгээр хурлуудаар хэлэлцүүлсэн сонирхлын зөрчилтэй хэлцлийг хуульд заасан байдлаар шийдвэрлэж, саналаа өгч баталгаажуулсан болно.
- Тайлангийн хугацаанд ТҮЗ-с гаргасан бүх шийдвэрийг санал хураалтад миний зүгээс сайтар судалж, дэмжсэн болохыг үүгээр баталж байна.

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 5176 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам"-ын 5 дугаар зүйлийн 5.1-т заасны дагуу ажлын тайлангаа тайлагнав.

Тайлан бичсэн:

Ариг банкны ТҮЗ-ийн дарга, хараат бус гишүүн,

Засаглал нэр дэвшүүлэх болон Цалин урамшууллын хорооны гишүүн



П.Мөнх-Эрдэнэ